БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2023/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2023 .02.17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа
Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuyad@gmal.com
Аудитор Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 14
4.1 Ерөнхий зүйл ........ 18
4.2 Материаллаг байдал ........ 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 19
5.Аудитын илрүүлэлт ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/36

танай ____________ -ны № ______________ -т

ӨЛЗИЙТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.СҮХЭЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга , журам өөрчлөн батлах тухай " ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч, Эрүүл мэндийн байгууллагууд нэг иргэнээр тооцсон нормативт зардлаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Үйл ажиллагааны орчинд бүтцийн өөрчлөлт гараагүй , дээрхи тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон зардлыг ЭМД-ын сангаас өвчний оношийн төрлөөр, насны ангилалаар тогтоосон тарифт үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

005020208

Дээрх өөрчлөлттэй холбоотойгоор Эрүүл мэндийн байгууллагууд 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн , орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **158,552,827.64** | **177,660,534.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 94,371,147.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 94,371,147.00 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 94,371,147.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 94,371,147.00 |
| **33** | **АВЛАГА** | 101,740,000.00 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 101,740,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 56,812,827.64 | 83,289,387.66 |
| **351** | **Түүхий эд материал** | 30,249,641.61 | 48,559,621.23 |
| 35130 | Эм боох материал | 30,249,641.61 | 48,559,621.23 |
| **354** | **Хангамжийн материал** | 26,563,186.03 | 34,729,766.43 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 711,000.00 | 1,377,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,235,049.00 | 19,185,689.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,093,000.00 | 1,897,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 231,269.98 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,009,300.00 | 1,021,800.00 |
| 35460 | Хүнсний материал | 93,900.00 | 575,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,189,667.05 | 10,672,527.43 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,275,722,306.19** | **1,343,403,078.09** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,275,722,306.19 | 1,343,403,078.09 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,269,058,306.19 | 1,333,637,078.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,286,145,610.00 | 1,301,145,610.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -73,935,217.72 | -106,427,635.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 7,000,000.00 | 57,120,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,527,777.72 | -9,187,499.92 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 126,682,745.57 | 177,356,573.57 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -85,640,554.59 | -104,139,727.17 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,073,578.20 | 52,614,378.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -22,740,077.55 | -34,844,621.59 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6,664,000.00 | 9,766,000.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,664,000.00 | 9,766,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,434,275,133.83** | **1,521,063,612.75** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,434,275,133.83** | **1,521,063,612.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,434,275,133.83 | 1,521,063,612.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 198,108,353.00 | 201,210,353.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 198,108,353.00 | 201,210,353.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 810,019,921.73 | 893,706,400.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 810,019,921.73 | 810,019,921.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 83,686,478.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 426,146,859.10 | 426,146,859.10 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,434,275,133.83** | **1,521,063,612.75** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **965,734,814.12** | **800,865,035.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **110,855,664.12** | **118,224,775.36** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 110,855,664.12 | 118,224,775.36 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 29,807,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 29,807,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ | 64,271,081.12 | 54,895,028.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | 46,584,583.00 | 33,522,747.36 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **854,879,150.00** | **682,640,260.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 455,397,100.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 455,397,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 324,815,146.00 | 105,494,123.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 74,880,646.00 | 105,494,123.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 49,646,074.00 | 49,625,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 49,646,074.00 | 49,625,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 25,020,830.00 | 527,520,637.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 25,020,830.00 | 527,520,637.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **813,251,410.42** | **717,178,556.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **813,251,410.42** | **717,178,556.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 761,292,275.42 | 713,682,146.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 328,039,828.00 | 347,757,785.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,907,172.00 | 204,424,340.00 |
| 210102 | Нэмэгдэл | 100,436,626.00 | 104,881,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,216,130.00 | 4,914,179.00 |
| 210104 | Урамшуулал | 33,479,900.00 | 33,538,066.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,022,881.00 | 44,175,433.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,399,535.00 | 30,521,424.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,555,530.00 | 3,144,513.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,456,156.00 | 2,885,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 646,913.00 | 684,922.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,964,747.00 | 6,938,674.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,908,874.00 | 45,817,790.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,527,874.00 | 4,843,138.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,581,000.00 | 40,974,652.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 84,642,105.41 | 46,634,999.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,564,850.00 | 16,715,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,727,264.02 | 20,082,669.98 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,703,201.00 | 3,456,980.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,201,505.00 | 304,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 31,781,415.49 | 3,558,560.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,566,841.90 | 2,517,139.62 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 24,097,028.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 86,815,628.32 | 118,434,963.74 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,935,794.82 | 105,323,863.74 |
| 210502 | Хоол, хүнс | 15,879,833.50 | 11,856,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 1,255,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,624,630.00 | 9,069,950.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 40,000.00 | 180,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,584,630.00 | 8,889,950.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 308,000.00 | 683,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 308,000.00 | 683,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 102,007,945.00 | 24,518,569.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 101,557,945.00 | 23,190,444.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 1,300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 28,125.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 65,922,383.69 | 76,589,056.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,920,719.00 | 6,833,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 54,001,664.69 | 69,755,856.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 51,959,135.00 | 3,496,410.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 41,187,846.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 41,187,846.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 963.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,770,326.00 | 3,496,410.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,770,326.00 | 3,496,410.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **152,483,403.70** | **83,686,478.92** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 665,508.05 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 665,508.05 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -665,508.05 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **151,817,895.65** | **83,686,478.92** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **753,139,150.00** | **814,187,260.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **29,807,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 29,807,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 29,807,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 29,807,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **753,139,150.00** | **784,380,260.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 455,397,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 223,075,146.00 | 105,494,123.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 74,880,646.00 | 105,494,123.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 49,646,074.00 | 49,625,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 49,646,074.00 | 49,625,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 25,020,830.00 | 629,260,637.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 25,020,830.00 | 629,260,637.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **730,829,150.00** | **640,376,513.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **730,829,150.00** | **640,376,513.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **720,057,861.00** | **636,880,103.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 328,039,828.00 | 347,757,785.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,907,172.00 | 204,424,340.00 |
| 210102 | Нэмэгдэл | 100,436,626.00 | 104,881,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,216,130.00 | 4,914,179.00 |
| 210104 | Урамшуулал | 33,479,900.00 | 33,538,066.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,022,881.00 | 44,175,433.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,809,318.00 | 30,521,424.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,802,895.00 | 3,144,513.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,139,297.00 | 2,885,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 783,987.00 | 684,922.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,487,384.00 | 6,938,674.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,908,874.00 | 45,817,790.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,527,874.00 | 4,843,138.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,581,000.00 | 40,974,652.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,373,851.00 | 33,083,430.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,686,850.00 | 4,138,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,840,100.00 | 19,851,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,703,201.00 | 3,456,980.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,893,700.00 | 304,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 5,332,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,005,395.00 | 65,871,249.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,196,100.00 | 48,495,049.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,299,295.00 | 10,563,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,510,000.00 | 6,813,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,624,630.00 | 11,112,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 40,000.00 | 1,510,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,584,630.00 | 9,602,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 308,000.00 | 683,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 308,000.00 | 683,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 222,324,183.00 | 64,509,466.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 221,874,183.00 | 62,951,341.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 1,300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 28,125.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 230,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,450,219.00 | 23,868,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,450,219.00 | 23,868,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,771,289.00** | **3,496,410.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 963.00 | 00.00 |
| 213404 | Хөрөнгийн | 963.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,770,326.00 | 3,496,410.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,770,326.00 | 3,496,410.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **22,310,000.00** | **173,810,747.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **22,310,000.00** | **79,439,600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,310,000.00** | **79,439,600.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 22,310,000.00 | 79,439,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 22,310,000.00 | 79,439,600.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-22,310,000.00** | **-79,439,600.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 94,371,147.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 94,371,147.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **426,146,859.10** | **810,019,921.73** | 1,434,275,133.83 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **426,146,859.10** | **810,019,921.73** | 1,434,275,133.83 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **198,108,353.00** | **426,146,859.10** | **810,019,921.73** | 1,434,275,133.83 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 3,102,000.00 | 00.00 | 00.00 | 3,102,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 83,686,478.92 | 83,686,478.92 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **201,210,353.00** | **426,146,859.10** | **893,706,400.65** | 1,521,063,612.75 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 656,520,400.00 | 610,825,580.00 | 45,694,820.00 | 93.0 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 656,520,400.00 | 610,825,580.00 | 45,694,820.00 | 93.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 656,520,400.00 | 610,825,580.00 | 45,694,820.00 | 93.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 360,726,500.00 | 347,757,785.00 | 12,968,715.00 | 96.4 |
| 210101 | Үндсэн цалин | 206,902,900.00 | 204,424,340.00 | 2,478,560.00 | 98.8 |
| 210102 | Нэмэгдэл | 104,881,200.00 | 104,881,200.00 | 0.00 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,006,000.00 | 4,914,179.00 | 1,091,821.00 | 81.8 |
| 210104 | Урамшуулал | 42,936,400.00 | 33,538,066.00 | 9,398,334.00 | 78.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,090,900.00 | 44,175,433.00 | 915,467.00 | 98.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,661,800.00 | 30,521,424.00 | 140,376.00 | 99.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,607,300.00 | 3,144,513.00 | 462,787.00 | 87.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,885,900.00 | 2,885,900.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 721,400.00 | 684,922.00 | 36,478.00 | 94.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,214,500.00 | 6,938,674.00 | 275,826.00 | 96.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,125,500.00 | 45,817,790.00 | 3,307,710.00 | 93.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,044,500.00 | 4,843,138.00 | 201,362.00 | 96.0 |
| 210302 | Түлш, халаалт | 42,581,000.00 | 40,974,652.00 | 1,606,348.00 | 96.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 00.00 | 1,500,000.00 | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,322,600.00 | 33,083,430.00 | 2,239,170.00 | 93.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,666,600.00 | 4,138,650.00 | 527,950.00 | 88.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,140,000.00 | 19,851,400.00 | 288,600.00 | 98.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,716,000.00 | 3,456,980.00 | 259,020.00 | 93.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 00.00 | 300,000.00 | 0.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,000,200.00 | 304,000.00 | 696,200.00 | 30.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,499,800.00 | 5,332,400.00 | 167,400.00 | 97.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 83,930,700.00 | 65,871,249.00 | 18,059,451.00 | 78.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 52,139,900.00 | 48,495,049.00 | 3,644,851.00 | 93.0 |
| 210502 | Хоол, хүнс | 10,582,900.00 | 10,563,200.00 | 19,700.00 | 99.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 21,207,900.00 | 6,813,000.00 | 14,394,900.00 | 32.1 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 48,044,800.00 | 44,541,450.00 | 3,503,350.00 | 92.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,544,800.00 | 19,938,800.00 | 2,606,000.00 | 88.4 |
| 210604 | Урсгал засвар | 25,500,000.00 | 24,602,650.00 | 897,350.00 | 96.5 |
| **2107** | **Томилолт,зочны зардал** | 700,000.00 | 683,600.00 | 16,400.00 | 97.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 700,000.00 | 683,600.00 | 16,400.00 | 97.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,153,600.00 | 2,685,343.00 | 1,468,257.00 | 64.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,700,000.00 | 1,127,218.00 | 572,782.00 | 66.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,300,000.00 | 1,300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 233,600.00 | 28,125.00 | 205,475.00 | 12.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,400.00 | 00.00 | 38,400.00 | 0.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 10,400.00 | 00.00 | 10,400.00 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 871,200.00 | 230,000.00 | 641,200.00 | 26.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29425800.00 | 26209500.00 | 3,216,300.00 | 89.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,425,800.00 | 26,209,500.00 | 3,216,300.00 | 89.1 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 656,520,400.00 | 705,196,727.00 | -48,676,327.00 | 107.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 49,625,500.00 | 46,129,090.00 | 3,496,410.00 | 93.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 49,625,500.00 | 46,129,090.00 | 3,496,410.00 | 93.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 576,087,900.00 | 629,260,637.00 | -53,172,737.00 | 109.2 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 576,087,900.00 | 629,260,637.00 | -53,172,737.00 | 109.2 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 30,807,000.00 | 29,807,000.00 | 1,000,000.00 | 96.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,807,000.00 | 29,807,000.00 | 1,000,000.00 | 96.8 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 24.00 | 2.00 | 92.3 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 18.00 | 2.00 | 90.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар "Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх" гэж зорилго зорилтыг тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

<u>Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :</u>

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад нийцүүлэн гарсан тогтоол, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин тайлант онд "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга , журам өөрчлөн батлах тухай " ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч , эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн журамд өөрчлөлт орж нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож эхэлсэн ба тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайлан ЭМЯ-нд нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс

2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,521,063.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 86,788.5 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Мянган төгрөгөөр

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 158,552.8 | 177,660.5 | 19,107.7 |
| Мөнгөн хөрөнгө | - | 94,371.1 | 94,371.1 |
| Авлага | 101,740.0 | - | (101,740.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 56,812.8 | 83,289.4 | 26,476.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,275,722.3 | 1,343,403.1 | 67,680.8 |
| Үндсэн хөрөнгө | 1,461,015.9 | 1,598,452.6 | 137,436.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (185,293.6) | (255,049.5) | (69,755.9) |
| **Нийт хөрөнгө** | 1,434,275.1 | 1,521,063.6 | 86,788.5 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,434,275.1 | 1,521,063.6 | 86,788.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,434,275.1 | 1,521,063.6 | 86,788.5 |

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 94,371.1 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын санхүү даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны өөрчлөлт нь өмнөх оны ЭМД-ын сангаас авах авлагын үлдэгдэл 101,740.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 83,289.4 мянган төгрөг болж 26,476.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 169,528.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн ЭМГ-аас болон ЭМГ-аар дамжуулан ЭМЯ бусад байгууллагаас 33,522.7 мянган төгрөгийн бараа, материалыг шилжүүлэн авч, 174,057,1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,517.1 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,598,452.6 мянган төгрөг болж 137,436.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 79,439.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЭМГ-аас 52,395.0 мянган, бусад эх үүсвэрээр 2,500.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч,төсвийн хөрөнгөөр хийгдсэн 15,000.0 мянган төгрөгийн их засварын ажлыг барилга байгууламжийн сайжруулалтаар бүртгэж, шинэ барилгын газрыг 3,102.0 мянган төгрөгөөр үнэлэн орлогод авсан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,521,063.6 мянган төгрөг болж 86,788.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 105,494.1 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн өмнөх оны ЭМД-гийн сангаас авах авлагын гүйлгээ байна. Нэмэлт санхүүжилтийн дансыг 2022 орны 3-р сарын 31-нээр дуусгавар болгон хаах болсонтой холбоотой зарцуулагдаагүй үлдэгдлийн 288.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн данс руу хааж, батлагдсан төсвийг нэмэгдүүлж өгсөн байна .

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд ЭМД-ийн сангаас санхүүжих нэг иргэнээр тооцсон зардлыг 661,525.8 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 151,131.2 мянган төгрөгөөр бууруулан 508,394.6 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой 8 удаа төсөвт өөрчлөлт оруулжээ

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 576,087.9 мянган , дээд шатны төсөв захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилан олгох буюу туслах үйл ажиллагааны орлогоос 30,807.0 мянган, орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлын санхүүжилтэд 49,625.5 мянган , нийт зарлага санхүүжилтийг 656,520.4 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 629,260.6 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 29,807.0 мянган , орон нутгийн төсвөөс 49,625.5 мянган , нийт 708,693.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 610,825.6 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 3,496.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ЭМД-ийн сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан 53,172.7 мянган төгрөгөөр илүү авсан, туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжиж, олгосон санхүүжилтээс 94,371.1 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 656,520.4 | 610,825.6 | -45,694.8 | 93.0 |
| АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ | 49,625.5 | 46,129.1 | -3,496.4 | 92.9 |
| АРГА ХЭМЖЭЭ 80302-Нэг иргэнд ногдох норматив зардал | 320,043.9 | 309,224.4 | -10,819.5 | 96.6 |
| АРГА ХЭМЖЭЭ 81603- Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 256,044.0 | 226,883.7 | -29,160.3 | 120.5 |
| АРГА ХЭМЖЭЭ 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан нэмэлт санхүүжилт | 30,807.0 | 28,588.4 | -2,218.6 | 92.8 |

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 105,782.2 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны ЭМД-гийн сангаас авах авлагын гүйлгээ байна. Нэмэлт санхүүжилтийн дансыг 2022 оны 3-р сарын 31-нээр дуусгавар болгон хаах болсонтой холбоотой зарцуулагдаагүй үлдэгдлийн 288.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн данс руу хааж, батлагдсан төсвийг нэмэгдүүлж өгсөн байна .

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Глобал капитал аудит" ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад 2022 оны -р сарын өөрчлөлтөөр батлагдсан төсөвт зардлын 555,744.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,336.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 6,252.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 656,520.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс 45,694.8 мянган төгрөгийг хэмнэсэн ба төрийн хэмнэлтийн хуулийн заалтад хамаарах дараах зардлыг хэмнэсэн байна. Үүнээс :

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3,496.4 мянган төгрөг
- Хангамж, бараа материалын зардлаас 2,239.1 мянган төгрөг
- Нормативт зардлаас 18,059.4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тайлант онд тендер зарлаагүй ба дулаанаар хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун , хүнсний материал худалдан авах 4 гэрээний 125,443.8 мянган, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 755,761.1 мянган төгрөгийн 18 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 83,890.0 мянган төгрөгийн 10 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 158,993.9 мянган төгрөгийн 10 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба аудитаар зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчил дутагдал илрээгүй.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн үлдэгдэл жил бүр нэмэгдэж байгаа тул төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нийлүүлэгдэж байгаа эмийн хугацаа, ашиглалт дээр анхаарч дүн шинжилгээ хийж төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах , төсвийн хөрөнгөөр авч буй үндсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, түүний чанар, ашиглалтын байдалд Эрүүл мэндийн салбарын хэмжээгээр давтан аудит хийхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

## 5.Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил, дутагдал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---